

ТЭЭВРИЙН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ МОНГОЛ  
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЛГАМДАХ АРДЧИЛСАН  
СОЛОНГОС АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХОРОНДЫН  
Х Э Л Э Л Ц Э Э Р

Монгол улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газар  
/шашид "Хэлэлцэн тохирогч Талууд" гэх/,

уламжлалт найрамдалт харилцааг иш үндэс болгон,  
тээврийн салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор,  
дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн орны нутаг дэвсгэр дээр  
нөгөө Талын дамжин өнгөрөх ачааны тээвэрлэлт явуулах таатай  
нөхцөлийг хангана.

1. Хэлэлцэн тохирогч Тал тус бүр дамжин өнгөрөх ачааны  
тээвэрлэлтийг зохион байгуулах, ашиглах зорилгоор энэхүү Хэлэл-  
цээрт заасан эрхүүдийг нөгөө Талдаа олгоно.

2. Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн орны нутаг дэвсгэр дээр  
төмөр зам ба авто тээврээр нөгөө Талын дамжин өнгөрөх ачааны  
тээвэрлэлтийг хангана.

3. Солонгосын Тал Монголын Талаас явуулсан бүх хөлөг онго-  
ныг өөрийн орны гадаад худалдааны боомтод нэвтрэн орох болон  
БНАСАУ-ын Чхонжин, Ражин, Сонбон боомтыг ашиглах зөвшөөрлийг  
олгоно.

4. Монголын Тал өөрийн агентлаг буюу суурин төлөөлөгч  
газрыг Чхонжин буюу Ражин боомтод байгуулж болно.

Хоёрдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд дамжин өнгөрөх ачааны тээвэр-  
лэлтийн хэтийн төлөвлөгөөг нөгөө Талдаа өгч тохиролж байна.

Бүртгэлийн дугаар 104

МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИЯЛСАН ДЭГЭЭ АЖИРАГЧИЙН  
ХУУЛБАР ҮНЭН

Хуульбар хэргийн ажилтан

2014 оны 3 сарын 4-ний өдөр

## Гуравдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд олон улсын хууль, дүрэм, түүнчлэн нөгөө Талын хууль, дүрмийг мөрдөж, түүний дагуу дамжин өнгөрөх ачааны тээвэрлэлтийн бичиг баримтын зохих бүрдүүлэлтийг хийнэ.

БНАСАУ-ын Чхонжин, Ражин, Сонсон боомтуудаар Монголын дамжин өнгөрөх ачаанд Солонгосын Тал гаалийн татвар ногдуулахгүй.

## Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр нөгөө Талын дамжин өнгөрөх ачааны бүрэн бүтэн байдлыг хангах, дамжуулан өнгөрөөх ажлыг уг ачааны физик-химийнх нь шинжийн дагуу гүйцэтгэнэ.

## Тавдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэр дээрх дамжин өнгөрөх ачааны тээвэрлэлттэй холбогдсон бүх зардлын тоолоог чөлөөтэй хөрвөх валютаар гүйцэтгэнэ. Гэхдээ зарим тохиолдолд, Талуудын тохиролцоогоор дээр дурдсан зардлыг чөлөөтэй хөрвөх валютаар борлуулах боломжтой барааг солилцох замаар төлж болно.

Хэлэлцэн тохирогч Талууд нь төмөр зам ба авто тээврээр гүйцэтгэсэн дамжин өнгөрөх ачааны тээвэрлэлт болон боомт дахь хөлөг онгоц, ачааны ажиллагаатай холбогдсон зардлын төлбөрийг Талуудын тээврийн байгууллагууд хоорондын гэрээгээр тогтоосон тарифын дагуу гүйцэтгэнэ.

## Зургадугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд нь дамжин өнгөрөх ачааны тээвэрлэлтэд саад учрахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай

Бүртгэлийн дугаар ..... 104 .....

МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ЗАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ

ХУУЛЬ АР ҮНЭН

Хуульбар амгасан амжилтан

Төрийн үсэг, гарын үсгийн байрлал  
2011-03-04



арга хэмжээ авч байх ба цаг агаарын тааламжгүй байдал болон бусад давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалж дамжин өнгөрөх ачааны тээвэрлэлт түр зогсох буюу саатах үед авах арга хэмжээг тохиролцон хэрэгжүүлнэ.

#### Долдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд жилд нэг удаа дамжин өнгөрөх ачааны тээврийн явцыг дүгнэж, дараа жилийн тээврийн төлөвлөгөөг тохирч байна.

#### Наймдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд нь нөгөө Талын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх ачааны тээвэрлэлт хийхдээ хууль тогтоомжийг нь зөрчих үйлдэл гаргахгүй байх шаардлагатай арга хэмжээ авч байна.

#### Есдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад гарах бүх маргааныг эв зүйтгээр шийдвэрлэж байна. Маргааныг эв зүйтгээр шийдвэрлэх боломжгүй тохиолдолд түүнийг олон улсын арбитрын байгууллагаар шийдвэрлүүлэх бөгөөд хариуцагч орны олон улсын арбитрын байгууллага нь арбитрын үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

#### Аравдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд нь энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх бүх талын асуудлыг хэлэлцэх болон тээвэрлэлтийн гэрээ байгуулахыг өөрийн орны тээврийн зохих байгууллагад үүрэг болгоно.

#### Арван нэгдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд бичгээр тохиролцсоноор энэхүү Хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Бүртгэлийн дугаар ..... 164 .....

МОНГОЛ УПСЫН  
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ

ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨВ

Хуулбар хэмсэм ажилтан

14 снч 3 сарын 4 ний өдөр

## Арван хоёрдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Талууд өөрсдийн орны хууль тогтоомжийн дагуу түүнийг батламжилсан тухай дипломат шугамаар харилцан мэдээлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, 5 жилийн хугацаанд мөрдөгдөнө. Хэрэв Хэлэлцэн Тохирогч аль нэг Тал нь Хэлэлцээрийг цуцлах тухай саналаа түүний хүчин төгөлдөр байх хугацаа дуусгавар болохоос 6 сарын өмнө нөгөө Талдаа бичгээр мэдэгдэхгүй бол энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа нь дараагийн 3 жилд аяндаа сунгагдана.

Энэхүү Хэлэлцээрийг Пхеньян хотноо 1996 оны 5 дугаар сарын 10 -ны өдөр монгол, солонгос, орос хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдэж гарын үсэг зурсан бөгөөд эх бичвэр тус бүр нь адил хүчинтэй байна.

Хэлэлцээрийг тайлбарлах явцад санал зөрвөл орос хэл дээрх эх бичвэрийг үндэс болгоно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ӨМНӨӨС

БҮГД НАЙРАМЛАХ АРДЧИЛСАН  
СОЛОНГОС АРД УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫН ӨМНӨӨС

Бүртгэлийн дугаар ..... 104 .....

МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИУЦААНЫ ТӨВ АРХИВ

КУУЛБАР ҮНЭН

Агуураар хянаж элжүүлсэн

20 14 3 4